



# ДЭЛГЭРХААН СУМЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

## 2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйл байвал 70272248  
дугаарын утаснаас лавлана уу?

Л.Жаргалсайхан

Дарга, тэргүүлэх аудитор  
өрөөний утас 70272582

О.Сосор - Аудитор  
өрөөний утас 70273204

Аймгийн Аудитын газар

Төрийн байгууллагын ордон

## Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

### АГУУЛГА

### ХУУДАС

|                                           |     |
|-------------------------------------------|-----|
| • Аудит хийж дууссан тухай мэдэгдэл ..... | 2-3 |
| • Танилцуулга .....                       | 4   |
| • Санхүүгийн дотоод хяналт .....          | 4-8 |
| • Гол шийдлүүд .....                      | 9   |
| • Тайлбар мэдүүлгийн захидал.....         | 9   |
| • Аудитын санал дүгнэлт .....             | 9   |

**Төв аймгийн Дэлгэрхаан сумын төсвийн байгууллагууд,  
тусгай сангууд 2013 оны Санхүүгийн Тайланд  
аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Дэлгэрхаан сумын төсөвт байгууллагууд болон тусгай сангуудын 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба Сумын Засаг дарга болон төсвийн шууд захирагч болон Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаархи бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Дэлгэрхаан сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

**Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг тодруулбал:**

- Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

**Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:**

- Орон нутгийн төсвийн татварын орлого-14551.1 мянган төгрөгөөр батлагдсан. Гүйцэтгэлээр орон нутгийн орлогын дансанд 14912.0 мянган төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө 860.9 мянган төгрөг буюу 106.1 хувиар биелүүлсэн байна.
- Хогны хаягдлын хураамж 784.1 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэлгүй байгаль хамгаалах санд оруулж зарцуулж Төсвийн тухай хуулийн 23.8.13 дахь заалтыг зөрчсөнд акт бичигдсэн.
- Сумын ИТХурал нь 2013 оны төсөв баталж тогтоол гаргахдаа зөвхөн орлого, НЕҮйлчилгээний төсвийг баталсан тогтоол гаргасан байгаа нь Сангийн сайдын 2012 оны 244-р тогтоолоор батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөв боловсруулах журам батлах тухай”, журмын хавсралтаар сумын ИТХурлын хуралдааны тогтоолын загварын дагуу хавсралтыг хийгээгүй зөрчил илэрсэн.
- Орон нутгийн орлогын данснаас Мал хамгаалах санд гүйлгээ хийсэн 2541.2 мянган төгрөгийг төлүүлэхээр акт бичигдсэн.

*ЕМ, Санхүүгийн албанаас  
ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын  
Газар тайлбар мэдүүлэг хүлээж байгаа  
илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар  
тайлбар ирүүлнэ үү*

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн, дээрх зөрчлүүд материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс бага тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар Ерөнхий аудиторт санал оруулсан байгаа

- ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх Аудитор 2014.03.25-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад нягтлан бодогч, нярав болон бусад албан тушаалтан бидэнтэй хамтран ажиллаж бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

## **ҮАГ-ЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР**

**2014.03.24**

## Танилцуулга

Дэлгэрхаан сумын 2013 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба сумын Засаг даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
- Жилийн санхүүгийн тайланд аудит хийх;

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

### Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

Аймгийн Аудитын газар санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Дэлгэрхаан сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын хяналтыг аймгийн Аудитын газрын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

Бид Дэлгэрхаан сумын Засаг дарга тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Дэлгэрхаан сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

### Орлого санхүүжилтийн талаар:

2013 оны НЕҮйлчилгээний батлагдсан төсөв 237345.7 мянган төгрөг, үүнээс орон нутгийн орлогооос 14551.1 мянган төгрөг, аймгаас санхүүгийн дэмжлэг 222694.7 мянган төгрөг авахаар батлагдсан. Гүйцэтгэлээр орон нутгийн орлогоос 8050.5 мянган төгрөг, аймгаас санхүүжилт 226500.6 мянган төгрөгийн санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн дансаар 10770.1 мянган төгрөгийг авч зарцуулсан.

Дэлгэрхаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2013 оны 01-р сарын 09-ний өдрийн 02-р тогтоолоор сумын Орон нутгийн төсвийн татварын орлогыг 16751.1 мянган төгрөгөөр баталсан. Орон нутгийн орлогод тодотгол хийж орлогын төлөвлөгөөг бууруулан 14551.1 мянган төгрөг болгон баталсан. Гүйцэтгэлээр орон нутгийн орлогын дансанд 14912.0 мянган төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө 860.9 мянган төгрөг буюу 106.1 хувиар биелүүлсэн байна.

Сумын ИТХурал нь 2013 оны төсөв баталж тогтоол гаргахдаа зөвхөн орлого, НЕҮйлчилгээний төсвийг баталсан тогтоол гаргасан байгаа нь сангийн сайдын 2012 оны 244-р тогтоолоор батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөв боловсруулах журам батлах тухай”, журмын хавсралтаар сумын ИТХурлын хуралдааны тогтоолын загварын дагуу хавсралтыг хийгээгүй зөрчил илэрсэн.

Мөн аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого батлагдсан төлөвлөгөөгөөр 57869.2 мянган төгрөг, гүйцэтгэлээр 64670.1 мянган төгрөг буюу биелэлт 111.8 хувьтай, улсын төсөвт төвлөрүүлэх орлого төлөвлөгөөгөөр 1200.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 2292.4 мянган төгрөг биелэлт 191.0 хувиар тус тус биелэсэн байна.

Төрийн сангийн төлөөлөгчийн гаргаж ирүүлсэн 2013 оны орлого, санхүүжилтийн нэгдсэн тайлангаар /нүүр тайлан/ Сумын орон нутгийн орлогын данс оны эхэнд 2541.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан. Тайлант онд орон нутгийн төсөвт төвлөрөх орлогоор 14912.0 мянган төгрөг төвлөрсөн. Орон нутгийн төсвөөс ЗДТГазарт 7700.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, мал хамгаалах санд зориулан 2541.2 мянган төгрөгийг орон нутгийн орлогын данснаас шууд шилжүүлж, үлдэгдэл 7212.0 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн.

НҮҮ-ний санхүүгийн дэмжлэгээр 222444,0 мянган төгрөг, орон нутгийн орлогоос 7700.0 мянган төгрөг, нийт 230144.0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн зарцуулсан байна. Санхүүгийн дэмжлэгээс ЗДТГазарт 158577.6 мянган төгрөг, ИТХуралд 32587.0 мянган төгрөг, Багт 31278.7 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Тусгай зориулалттай шилжүүлгээр ЕБСургуульд 444688.5 мянган төгрөг, Цэцэрлэгт 170667.5 мянган төгрөг, Эмнэлэгт 180741.7 мянган төгрөг, Соёлын төвд 48423.0 мянган төгрөг нийт 844520.7 мянган төгрөгийн эх үүсвэрийг нэгтгэсэн байна. НҮҮйлчилгээний байгууллагуудын оны эхний харилцах дансны үлдэгдэл 7676.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Халамжийн сангийн санхүүжилт 164387.9 мянган төгрөг төгрөгийг халамж үйлчилгээний санд төвлөрүүлснээс халамжийн тэтгэвэрт 129927.5 мянган төгрөг, жирэмсэн амаржсан эхийн тэтгэмжинд 25005.3 мянган төгрөг, хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 8170.0 мянган төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн зардалд 1285.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн дансны санхүүжилтээр ЗДТГазарт 10770.1 мянган төгрөг, Сургууль 2253.8 мянган төгрөг, ЭМТөв 142.0 мянган төгрөг, нийт 13165.9 мянган төгрөгийн орлого, 12808.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэст 357.4 мянган төгрөгийн үлдэгдэлийг мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд нэгтгэсэн.

Төсөвт байгууллагын өөрийн орлогоор Тамгын газарт 350.0 мянган төгрөг нэгтгэгдсэн байна.

#### **Мөнгөн хөрөнгийн талаар:**

Сумын нэгдсэн тайлангаар оны эхэнд ЗДТГазар 5964.6 мянган төгрөг, ИТХурал 17.1 мянган төгрөг, Баг 1694.2 мянган төгрөг, нийт 7676.0 мянган төгрөг, Тусгай зориулалтийн сангууд 21354.5 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 2541.2 мянган төгрөг, эм эргэлтийн сан 517.0 мянган төгрөг, нийт 98391.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан.

Жилийн эцсийн байдлаар Тусгай зориулалтийн сангууд 18205.0 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 7212.0 мянган төгрөг, эм эргэлтийн сан 4924.0 мянган төгрөг, Нэмэлт төсвийн санхүүжилтийн дансны үлдэгдэл 215.4, нийт 30556.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Энэ Төрийн сангийн төлөөлөгчийн ирүүлсэн үлдэгдлийн баталгаагаатай болон ХААН банкнаас ирүүлсэн эм эргэлтийн сангийн үлдэгдлийн баталгаагаатай тохирч байна.

#### **Авлага, өглөгийн талаар:**

Сумын нэгдсэн тайлангаар Оны эхэнд 26211.3 мянган төгрөгийн авлага, оны эцэст 27287.8 мянган төгрөгийн авлагатай нэгтгэгдсэн ба оны эхнээс авлага 1076.0 мянган төгрөгөөр өссөн ба жилийн эцсийн нийт авлагын 26211.3 мянган төгрөгийн буюу 96.0 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна. Хүмүүсээс авах зээлийн үлдэгдэл-198394.2 мянган төгрөг, хүү 5826.3 мянган төгрөг, нийт авлага 204220.5 мянган төгрөг байхад тайлан тэнцэлд 178009.2 мянган төгрөгөөр дутуу тусгасан байна. Өглөг оны эхэнд 8145.7 мянган төгрөг, оны эцэст 6589,0 мянган төгрөгийн өглөгтэй нэгтгэгдсэн байна. Оны эцсийн өглөгийг задалбал Дунд сургууль 3270.0 мянган төгрөгийн томилолтын өртэй, НЕҮйлчилгээний байгууллагууд 2582.9 мянган төгрөгийн өртэй байна.

#### **Бараа материал**

Сумын нэгдсэн тайлангаар Бараа материалын данс нь оны эхэнд 79557.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан, жилийн эцэст 53837.9 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

#### **Үндсэн хөрөнгө**

Сумын нэгдсэн тайлангаар Үндсэн хөрөнгийн данс нь оны эхэнд 2535971.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан, жилийн эцэст 2518182.1 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

#### **Тусгай зориулалтын сангууд**

Сумын хэмжээнд 7 сан үйл ажиллагаа явуулж байгаа ба эм эргэлтийн сангаас бусад сан Төрийн сангийн харилцах дансаар гүйлгээ хийгдэж хянагддаг байна. Сангуудыг тодруулахад:

**Байгаль хамгаалах сангийн эхний** үлдэгдэл -1959.0 мянган төгрөг, тайлант онд орлого 10384.1 мянган төгрөг/аймгаас санхүүжилт-5430.0 мянган төгрөг, худгийн засварт 2800.0 мянган төгрөг, хогны төлбөр-784.1 мянган төгрөг, мал хамгаалах санд 1170.0 мянган төгрөг, 200.0 мянган төгрөг биотехник арга хэмжээний зардал /орсон. Зарцуулалт нь худаг засварт-2800.0 мянган төгрөг, хөрөнгө худалдан авахад-3530.0 мянган төгрөг, булгийн эх хамгалахад-1500.0 мянган төгрөг, худгийн насос авахад 350.0 мянган төгрөг, байгаль хамгаалах арга хэмжээнд 162.5 мянган төгрөг, ОН Байцаагчийн урамшуулалд -153.6 мянган төгрөг, шатахуунд 173.8 мянган төгрөг, мал хамгаалахын 1170.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

**Мал хамгаалах сангийн** эхний үлдэгдэл 4983.2 мянган төгрөг, /Аймгийн Засаг даргын 2012.12.18 ны өдрийн а/638 тоот захирамжаар аймгийн нөөцөөс сумдад өвс тэжээл татах зардал 2252.4 мянган төгрөг 2012 оны эцсээр дансанд орж үлдэгдлээр гарсан. тайлант онд орлого 5179.5 мянган төгрөг, Баян -өндөр сумаас бэлчээрийн хураамж-1400.0 мянган төгрөг, өвс борлуулсны орлого-3779.5 мянган төгрөг/- орсон байна. Заамар сумын Тосон овоот хайрхан ХХК-д тээврийн зардал-2252.4 мянган төгрөг, өвс тэжээлийн үнэнд-мянган төгрөг зарцуулсан байна. Оны эцэст 486.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**ГХУССангийн** эхний үлдэгдэл 286,0 мянган төгрөг, тайлант онд ГХУС зардалд 658.6 мянган төгрөг орж, зарлага 313.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл-631.2 мянган төгрөг байна.

**БОНСБарьцаа сангийн** эхний үлдэгдэл 3277.5 мянган төгрөг, тайлангийн хугацаанд Болор анар ХХК, Миллениум сторм ХХК, Ди Эс Эн Кэй ХХК –иудаас 950.0 мянган

төгрөг орсон.Зарлагын гүйлгээ гараагүй ,оны эцэст 4227.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Сум хөгжүүлэх сан.** Оны эхний үлдэгдэл **9199.2** мянган төгрөг.Тайлангийн хугацаанд аймгаас 100.0 сая төгрөгийн санхүүжилт,зээлийн төлбөр-15083,1мянган төгрөг, хүүгийн төлбөр 1499.3 мянган төгрөг,нийт 116582.4 мянган төгрөг орсон.2013 онд 36 сарын хугацаатай 23 иргэнд 120200,0 мянган төгрөгийн зээл,үйл ажиллагааны зардалд 1050.0 төгрөг зарцуулсан. Оны эцсийн дансны үлдэгдэл 4531.6 мянган төгрөг байна. Зээлийн авлага 47 иргэнтэй холбоотой 198394.3 мянган төгрөг зээл,хүүгийн авлага5826.3 мянган төгрөг байна.Хугацаа хэтэрсэн зээл 5 иргэний 5476.1мянган төгрөг,хүү 2159.3 мянган төгрөг байна.

**Орон нутгийн хөгжлийн сан.** Дэлгэрхаан сумын ИТХурлын 2013 оны 03-р сарын 29 ны өдрийн 14 тоот тогтоолоор сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр ,төсөл арга хэмжээний 14 ажлын жагсаалтыг 184800.0 мянган төгрөгөөр батласан байна.

Оны эхэнд үлдэгдэлгүй.Тайлант онд аймгаас 110165.1 мянган төгрөг, хандив 2300.0 мянган төгрөг,нийт 112465.1 мянган төгрөгийн орлого орсон. Иргэний танхимд 13000.0мянган төгрөг, сумын өндөрлөг 5000.0мянган төгрөг,Хүүхэд залуучуудын соёл амралтын талбай -56960.0 мянган төгрөг, гэрэлтүүлэг 20000.0мянган төгрөг,Наадмын зардал 7000.0 мянган төгрөг,дээврийн засвар 6000.0 мянган төгрөг, нийт 108260.0 мянган төгрөг зарцуулж,оны эцэст 4205.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

**Эм эргэлтийн сангийн** оны эхний үлдэгдэл 517.0 мянган төгрөг , тайлант онд 11526.2 мянган төгрөгийн орлого орж, 7119.3 мянган төгрөг зарцуулж, оны эцэст 4924.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан хэсгүүдийн дотоод хяналтын систем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

### **Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд**

Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах
- Санхүүгийн тайлан гаргалт уялдаа холбоог сайжруулах

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

### **Залруулагдаагүй алдаа**

1. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар илрүүлсэн алдаануудыг төсөвт байгууллагуудад залруулсан ба нэгтгэлд залруулагдаагүй алдаа байхгүй болно.

### **Тайлбар мэдүүлгийн захидал**

2. Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

### **Аудитын санал дүгнэлт**

3. Аймгийн Аудитын газраас танай байгууллагын 2013 оны 12 дугаар сарын 31 –нээр тасалбар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайланд **зөрчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2014.03.25